



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/43

Мөрөн

Улирлын тайлан гаргах, дүгнэх,
үр дүнгийн урамшуулал олгох журамд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 98, 301, 442 дугаар тогтоолууд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.6 дахь заалт, 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн ажилтан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үр дүнг тооцох журмыг хавсралтаар баталсугай.


2.Харьяа салбаруудад тайлан, илтгэх хуудас бичих загварт өөрчлөлт оруулан шинэчилж хүргүүлэн мөрдөж ажиллахыг цаг уур орчны технологийн хэлтсийн дарга (Э.Баяржаргал)-д үүрэг болгосугай.

3.Журмын дагуу албан хаагчдын ажлыг улирал, хагас бүтэн жилээр нэгтгэн дүгнэж дүнг зөвлөлийн хуралд танилцуулж байхыг цаг уур орчны технологийн хэлтсийн дарга (Э.Баяржаргал)-д даалгасугай.

4.Улирал, хагас жилийн ажлын үр дүнг үндэслэн үндсэн цалингаас үр дүнгийн урамшууллыг тухай бүр тооцож олгохыг ахлах нягтлан бодогч (Ц.Бямбажав)-д зөвшөөрсүгэй.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2023 оны А/19 дүгээр тушаалыг хүчингүй тооцсугай.

ДАРГА



Б.ӨНӨРБАТ

105252200

Төвийн даргын 2023 оны 12 дугаар сарын
18-ны өдрийн А/43 дугаар тушаалын хавсралт

**УЛИРАЛ, ХАГАС, БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАН ГАРГАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ,
ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж үр дүнгийн урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна нотолгоонд суурилсан, бодитой, шударга байх зарчмыг баримтална.

**ХОЁР. АЛБАН ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ, ТАЙЛАН ГАРГАХ,
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

2.1. Байгууллагын бүх албан хаагч Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулж 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариуцсан нэгжийн удирдах ажилтанд цахим хэлбэрээр өгнө. Гүйцэтгэлийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр гарган, улирлын гүйцэтгэлийн тайланг 04, 07, 10, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг 06 дугаар сарын 01, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор салбар хариуцсан нэгжийн удирдах ажилтанд цахим хэлбэрээр өгнө. Тус тайландаа өртөө харуулд хийгдсэн шинжилгээний хөтөлбөрт ажил болон орон нутгийн ажилд оролцсон байдал, орон нутгийн хөрөнгө оруулалт зэрэг бусад ажлын талаар дэлгэрэнгүй бичнэ.

2.2. Төвийн дарга нь нэгжийн дарга нарын, нэгжийн дарга нар нь салбарын инженерүүдийн болон захиргааны албан хаагчдын, салбар хариуцсан инженерүүд нь ахлах техникч, техникч, ажиглагч, газогенераторчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний болон албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн хөтөлбөрт ажлын биелэлт, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний биелэлт, хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, олон нийтийг хамарсан ажил, сургалт, хурал зөвлөгөөнд оролцсон оролцоог үнэлсэн үнэлгээг "Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны 301, 442 дугаар тогтоолын хавсралтыг" удирдлага болгон үнэлнэ. Гүйцэтгэлийн тайланг үнэлсэн үнэлгээний хуудсыг цахим болон цаасан хэлбэрээр гаргаж болно.

2.3. "Дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний баг" нь гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээг хянаж төвийн даргаар батлуулна. Тус баг гүйцэтгэлийн тайлангийн дахин үнэлгээ болон гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны 301, 442 дугаар тогтоолын хавсралтыг удирдлага болгоно.

**ГУРАВ. ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХОД БАРИМТЛАХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ, АРГАЧЛАЛ**



3.1. Албан тушаалын тодорхойлолт, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан үндсэн ажил, үүргийн биелэлтийг үнэлэхэд дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

Албан тушаал	Шалгуур үзүүлэлт	Оноо
Төвийн удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний болон албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн хөтөлбөрт ажлын биелэлт	0-70
	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний биелэлт (Салбар хариуцсан инженерүүдийн үнэлгээ)	0-15
	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	0-7
	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	0-3
	Өгсөн үүрэг даалгаврын биелэлт, олон нийтийг хамарсан ажил, сургалт, хурал зөвлөгөөнд оролцсон оролцоог үнэлсэн үнэлгээ (Захиргааны нэгжийн даргын үнэлгээ)	0-5
	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98-р тогтоолын аргачлалын 6-р хэсэгт заасан холбогдох заалтаар)	...

3.2. Төвийн дарга нь гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр “Хэвийн” болон “Маш сайн” үнэлгээ авсан албан хаагчдад байгууллагын төсвөөс хамаарч үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг тогтоож улирал болон хагас бүтэн жилээр үндсэн цалингаас тооцон олгож болно. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр үр дүнгийн урамшууллыг олгож болно:

Шалгуур үзүүлэлтийн нийт оноо	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Урамшуулал тооцох хувь, %
85-100	Маш сайн	50 хүртэл
70-84.9	Хэвийн	-
<70	Хангалтгүй	-

ДӨРӨВ. ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХГҮЙ БАЙХ ҮНДЭСЛЭЛ

4.1. Албан хаагчдад дараах үндэслэлээр үр дүнгийн урамшуулал олгохгүй.


4.1.1. Шалгуур үзүүлэлтийн нийт оноо 70%-аас доош “Хангалтгүй” үнэлгээтэй бол;

4.1.2. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байгаа бол (сахилгын шийтгэл эхэлснээс 1 жилийн хугацаанд);

4.1.3. Шинээр ажилд ороод улирлын үр дүнгийн урамшуулал тооцоход 3 сар, хагас жилийн үр дүнгийн урамшуулал тооцоход 6 сарын турш бүрэн ажиллаагүй бол;

4.1.4. Хүүхэд асрах чөлөөтэй байсан албан хаагч ажилдаа орсон эхний 3 сар;

**ТАВ. УС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУРЫН ӨРТӨӨ, ХАРУУЛУУДЫН ТЕХНИКЧ
АЖИГЛАГЧ,
УС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУРЫН АХЛАХ ТЕХНИКЧДИЙН АЖЛЫГ ДҮГНЭХДЭЭ
НАРИЙВЧЛАН ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**



5.1. Арга хэмжээний биелэлтийг 70 хүртэлх оноогоор үнэлэх бөгөөд арга хэмжээний гүйцэтгэлд 100 хувиар тооцож 0-60 оноог доорх үзүүлэлтээр дүгнэж харгалзах оноог өгнө:

5.1.1. Төвийн "Ажил дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох, оны тэргүүний салбар нэгж, тэргүүний ажилтан шалгаруулах журам"-ын дагуу дүгнэгдсэн шинжилгээний ажлын дүн.

5.1.2. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийн үнэлгээ.

Гүйцэтгэлийн тайланг албан бичгийн стандартын дагуу, хугацаандаа үнэн зөв бичсэн бол 100%:

5.1.2.1. Гүйцэтгэлийн тайланг хугацаандаа дамжуулаагүй хоцроосон тохиолдолд -1.0;

5.1.2.2. Албан бичгийн стандарт мөрдөөгүй тохиолдол тутамд -1.0;

5.1.2.3. Шинжилгээний ажлын дүнг үнэн зөв бичсэн эсэх -1.0;

5.2. Арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдалд 100 хувиар тооцож 0-10 оноогоор үнэлнэ.

Ажиглалтын дэвтэр, материал болон эх мэдээ цахимаар хугацаандаа явуулсан бол 100%:

5.2.1. Өртөө, харуулын цахим мэдээг сар бүрийн 3-ны дотор дамжуулсан байх бөгөөд хугацаа хоцроосон хоног тутамд -2.0;

5.2.2. Өртөө, харуулын цаасан тайланг сар бүрийн 5-ны дотор ирүүлсэн байх бөгөөд хугацаа хоцроосон хоног тутамд -2.0;

5.2.3. Агро дундаж мэдээг сар бүрийн 10, 20, 30 (31)-ний зарласан хугацаанд утсаар өгсөн эсэх. -3.0;

5.3. Мэдээлэл үйлчилгээний хэлтсээс погода, аюул-агаар мэдээ зохиолт, дамжуулалтад алдаа гаргасан, хоцроосон, тасалсан тохиолдолд тухайн албан хаагчийн үндсэн үүргийн биелэлтийн дүнгээс дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ:

5.3.1. Алдаатай мэдээ дамжуулж, ээлжийн синоптик инженер тухайн алдааг хэлж засуулсан тохиолдол бүрд; -1%;

5.3.2. Алдаатай мэдээгээ засаж хоцроосон тохиолдол бүрд -1%;

5.3.3. Мэдээг шалтгаангүй хоцроосон тохиолдол бүрд -5%;

5.3.4. Мэдээг тасалсан тохиолдол бүрд -10%;

5.3.5. Мэдээг хуурамчаар үйлдсэн бол тасалсанд тооцно -10%;

Тайлбар: шалтгаангүй хоцроосон гэдэгт өртөө hh:10-hh:30 минут, харуул hh:30-hh:50, тасалсан гэдэгт өртөө hh:31, харуул hh:51 минутаас хойш дамжуулсан хугацааг тооцно. hh-ажиглалтын үндсэн хугацаа.

5.4.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг 0-15 оноогоор үнэлэх бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан сургалт, арга хэмжээнд хэрхэн хамрагдсаныг үндэслэн дүгнэнэ.

**ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР,
АХЛАХ ТЕХНИКЧ, ТЕХНИКЧИЙН АЖЛЫГ ДҮГНЭХДЭЭ НАРИЙВЧЛАН ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

6.1.Арга хэмжээний биелэлтийг 70 хүртэлх оноогоор үнэлэх бөгөөд арга хэмжээний гүйцэтгэлд 100 хувиар тооцож 0-60 оноог доорх үзүүлэлтээр дүгнэж харгалзах оноог өгнө:

6.1.1.Төвийн "Ажил дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох, оны тэргүүний салбар нэгж, тэргүүний ажилтан шалгаруулах журам"-ын дагуу инженер, техникч нарын шинжилгээний ажлыг дүнгээр тооцох;

6.1.2.Гүйцэтгэлийн тайлагналт, хугацаа, бүрэн гүйцэд байдлыг шалгасан үнэлгээ.

Гүйцэтгэлийн тайланг үнэлэхдээ хугацаандаа албан бичгийн стандартын дагуу бичсэн, шинжилгээний ажлаа бүрэн үнэн зөв тайлагнасан бол 100%:

6.1.2.1.Албан бичгийн стандартын мөрдөөгүй тохиолдол тутамд -1.0;

6.1.2.2.Шинжилгээний ажлаа бүрэн тайлагнасан эсэх -1.0;

6.1.2.3.Гүйцэтгэлийн тайланг хугацаандаа ирүүлээгүй хоцроосон тохиолдолд -1.0;

6.2.Арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдалд 100 хувиар тооцож 0-10 оноогоор үнэлнэ.

Шинжилгээг хугацаанд нь хийж холбогдох дэвтэр хүснэгт, бодолт, тооцооллыг хийж, шинжилгээний дүнг хугацаанд нь мэдээллийн санд оруулсан, гүйцэтгэлийн тайланг хугацаандаа ирүүл бол 100%:

6.2.1.Усны шинжилгээний дүнг сар бүрийн 5-ны дотор цахим мэдээллийн санд оруулах, хугацаа хоцорсон хоног тутамд -1.0;

6.2.2.Агаарын шинжилгээний дүнг өдөр бүр 12 цагаас өмнө цахим мэдээллийн санд оруулах, хугацаа хоцорсон хоног тутамд -0.5;

6.2.3.Хөрсний шинжилгээний дүнг дараа сарын 5-ны дотор цахим мэдээллийн санд оруулах, хугацаа хоцорсон хоног тутамд -1.0.

6.3.Байгаль орчны шинжилгээний лабораторийн инженер, ахлах техникч, техникч нарын мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний биелэлтийг тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаар нь тооцож биелэлтийг 0-15 оноогоор дүгнэнэ.